

“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ-ЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

“Улаанбаатар лифт” НӨҮГ-т хандаж иргэд, ААНБ, СӨХ-оос 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 19 өргөдөл ирсэн байна. Үүнээс 13 гомдол, 5 хүсэлт, 1 санал ирснийг 100% шийдвэрлэсэн байна. Хугацаа хэтэрч хаагдсан өргөдөл, гомдол байхгүй. Шийдвэрлээгүй, судалж буй гомдол байхгүй байна. Өргөдөл, гомдлыг цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажиллахын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Өргөдөл, гомдлын нэгдсэн систем <http://erp.ulaanbaatar.mn> програмын ашиглалт, хэрэглээний талаар байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх түвшний албан хаагчдад шийдвэрлэлтийг анхаарч ажиллахыг үүрэгжүүлсэн.
- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 9 хоногт багтаан шийдвэрлэхээр зорьж ажилласан ба зорилтдоо хүрч ажиллаж байна.

Хандалтын байдлаар 2024-2025 он дамжин хэрэгжсэн орон сууцны цахилгаан шатны шинэчлэлийн ажил болон улсын комисс ажиллахтай холбоотой өргөдөл, гомдол дийлэнх хувийг эзэлж байна. Өргөдөл, гомдлыг цаг хугацаандаа шийдвэрлэхэд нь хяналт тавин ажилласан.

Өргөдөл гаргасан иргэн, ААНБ, СӨХ-той газар дээр нь очиж биечлэн уулзах, утсаар холбогдон хариу өгөх зэргээр түргэн шуурхай хугацаанд иргэний талд өргөдөл, гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна.

- Тайлант хугацаанд байгууллагын зүгээс гэрээт сууц өмчлөгчдийн холбооны дарга нартай хэсэгчилсэн уулзалт зохион байгуулсан.
- Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тутамдаа газрын даргад танилцуулж хэвшсэн.
- Тайлан мэдээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн, мөн шийдвэрлэлтийн явцад удаа дараа зөрчил гаргасан албан хаагч байхгүй.

Цаашид манай байгууллагад хандаж иргэд болон ААНБ, СӨХ-ноос ирсэн өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэхийг зорьж байна.

ХЯНАСАН:
ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ДОТООД
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Д.ГАН-ЭРДЭНЭ

Номинч. Э.НОМИН-ЭРДЭНЭ

**“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ**

Хамрах хугацаа: 2025/01/31-2025/12/30

2025 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Д/д	Хаанаас (Хэнээс) ирүүлсэн	Хүлээн авсан он, сар, өдөр	Агуулга	Шилжүүлсэн газар, алба, ажилтан	Хэрхэн шийдвэрлэсэн	Хариу өгсөн хэлбэр (он, сар, өдөр, амаар болон бичгээр)	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8
1	Хүсэлт (Иргэн Д.Алтанцэцэг 99049575)	2025.01.14	ХУД-ийн 120-ын автобусны буудлын гүүрэн гарцын лифтийг өдөр бүр орой 20 цагаас зогсоох биш хойш ажиллуулах шаардлагатай байна. Асуудлыг шийдвэрлэж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн Д.Алтанцэцэгтэй утсаар холбогдож санал солилцов. Хүсэлтийг холбогдох шатны байгууллагад уламжлахаар болов.	2025.01.16 утсаар мэдээлэл өгсөн	
2	Гомдол (Иргэн Д.Найданжав 94116012)	2025.02.06	ХУД-ийн 120-н өндөр шат ажиллахгүй байна. Шалгаж, арга хэмжээ авч өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	120 -ын гүүрэн гарцын цахилгаан шатыг хэвийн ажиллагаанд оруулав. Иргэн Д.Найданжавт утсаар холбогдож мэдэгдсэн.	2025.02.11 утсаар мэдээлэл өгсөн	
3	Гомдол (Иргэн Д.Ариунболор 99048786)	2025.02.07	ХУД-ийн 2-р хороо 19-ийн үйлчилгээний төвийн автобусны буудлын гүүрэн гарцын цахилгаан шат нь ажиллахгүй байна. Халтиргаа гулгаа ихтэй настай хүмүүс унаж гэмтэх аюулд орж	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	19-ийн гүүрэн гарцын цахилгаан шатыг хэвийн ажиллагаанд оруулав.	2025.02.11 утсаар мэдээлэл өгсөн	

			байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.				
4	Гомдол (Иргэн Б.Нандинханд 94321002)	2025.02.24	СБД-ийн 100 айлд байдаг гүүрний лифтийг ажиллуулж өгнө үү. Өндөр настууд, хүүхдүүд халтирч унаад бэртэж, гэмтэх эрсдэлтэй байна.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн Б.Нандинхандтай утсаар холбогдож сэлбэггүй улмаас 100 айлын гүүрэн гарцын хойд лифт ажиллахгүй байгаа талаар мэдэгдэв. Сэлбэгийн захиалга хийгдсэн боловч Хятадын цагаан сар болсонтой холбоотой тээвэрлэлт удаширч байгаа талаар сэлбэг нийлүүлэгч тал мэдэгдсэн.Сэлбэг ирмэгц хэвийн ажиллагаанд оруулах талаар иргэнд утсаар мэдэгдэв.	2025.03.06 утсаар мэдээлэл өгсөн	
5	Хүсэлт (Иргэн С.Энхтөмөр 88626482)	2025.03.31	СБД-ийн 100 айлын гүүрэн гарцын цахилгаан шат ажиллахгүй байна. Энэ асуудлыг шийдэж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	100 айлын гүүрэн гарцын цахилгаан шатны гэмтэл арилгаж хэвийн ажиллагаанд оруулав. 100 айлын хойд цахилгаан шатын хаалганы мотор, инвертор сольж ажиллагааг хэвийн болгов.	2025.04.01 утсаар мэдээлэл өгсөн	
6	Гомдол (Иргэн С.Энхтөр 99047106)	2025.04.02	100 айлын гүүрэн гарцын цахилгаан шат ажиллахгүй байгаа. Би хөгжлийн бэрхшээлтэй иргэн юм. Тус гүүрээр гарахдаа, хүнээр үүрүүлж гарч байна. Холбогдох газарт нь хэлэхэд ерөнхий инженер н.Энхбат нь 70162680 дугаараас цахилгаан шат хэвийн болсон гэж холбогдсон. Гэтэл бодит байдал дээрээ цахилгаан шат нь ажиллахгүй байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн С.Энхтөмөрийн мэдээллийн дагуу механик инженер Б.Намуундөл, механик Л.Ангараг нар 100 айлын гүүрэн гарцын цахилгаан шатын ажиллагааг шалгасан. 100 айлын гүүрэн гарцын цахилгаан шат хэвийн ажиллаж байгаа талаар иргэн С.Энхтөмөрт утсаар холбогдож мэдээлсэн.	2025.04.14 утсаар мэдээлэл өгсөн	
7	Хүсэлт (Иргэн С.Чинзориг 99119909)	2025.04.21	"Улаанбаатар лифт" ОНӨҮГ гэж хүнд сурталтай байгууллага байна аа. Утас авахгүй, дуудлага өгөхөөр ирэхгүй, ирэхээрээ лифт янзалсан	Инженер техникийн хэсэг, ерөнхий	Хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 18 цаг 31 минутад Гандирас СӨХ-ны дарга	2025.04.22 биеэр уулзаж хариу	

			гэх боловч тун удахгүй эвдэрчихнэ. Хагас сайн, бүтэн сайнд амарна гээд алга болчихно. Гомдол хэлэхээр н.Батзориг гэх хяналтын хүн нь гэрээгээ цуцлаад өөр газраар хийлгэхгүй юу гэж тавлана. Төрийн өмчийн нэртэй иймэрхүү бугшиж хэнэггүй болсон газраа цэгцлээд, болохгүй бол хувьд өгөх хэрэгтэй байна. Өнгөрсөн 5 дах өдрөөс хойш хүүхэд хөгшид 13 давхар руу алхаад хэцүү байна шүү. Утас нь: 70162680	инженер М.Энхбат	С.Чинзоригийг байлцуулан контактор сольж лифтийг хэвийн ажиллагаанд оруулсан.	хүргүүлсэн
8	Гомдол (Иргэн Д.Гантулга 99010805)	2025.06.12	СБД-ийн 5 дугаар хорооны 56 байрны оршин суугч байна. Манай байрны лифт гацахаас гадна доошоо алдаад байгаа юм. Улаанбаатар лифт гэдэг компани хариуцдаг бөгөөд СӨХ-ноос удаа дараа хандаад завсарлаж өгөхгүй 3 сар болж байна. Энэ асуудалд гомдолтой байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Гомдол гаргагч иргэн Д.Гантулга лифтийн одоогийн байдлаар танилцуулж тайлбарласан болно. Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу цаг хугацаанд нь дуудлагын дагуу очиж гэмтлийг устган хэвийн ажиллагааг ханган ажиллаж байгаа талаар мэдэгдсэн.	2025.06.20 утсаар мэдээлэл өгсөн
9	Хүсэлт (Иргэн Д.Найдандорж 94116012)	2025.06.17	19-р хорооллын гүүрэн гарцын цахилгаан шат ажиллахгүй олон хонож байна. Ажил хийхгүй иргэдийг хохироож байна. Цахилгаан байхгүй гээд том цаас наачхаад л байгаад байх юм	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн Д.Найдандоржийн хүсэлтийн дагуу утсаар холбогдож тэжээлийн кабель гэмтсэний улмаас ажиллахгүй байгаа талаар тайлбар өгөв. Тэжээлийн кабель шинэчлэх ажлын бэлтгэл ажил хангагдсан талаар УБЗААГ-ын инженер Эрдэнэбаатар мэдэгдсэн.	2025.06.19 утсаар мэдээлэл өгсөн
10	Гомдол (Ц.Дашдорж 99155049)	2025.06.18	СБД-ийн 7 дугаар хорооны 56 байрны оршин суугч байна. Манай цахилгаан шат ажиллахаа болиод 6 сар болж байна. Төрийн өмчит Улаанбаатар лифтийн компани манай цахилгаан шатыг засаж	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Захиалсан сэлбэг ирж суурилуулан лифтийг хэвийн ажиллагаанд оруулсан.	2025.07.03 утсаар мэдээлэл өгсөн

				<p>өгөхгүй сунжуулаад байна. Энэ асуудлыг шийдэж өгнө үү.</p>												
11	Гомдол (Т.Даваадулам 86068876)	2025.06.19		<p>Би Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо 54-р байрны СӨХ-оос холбогдож байна аа. Манай байрны 1 дүгээр орцны лифтийг Пүүжи Элеватор гэдэг компани 11 сард угсарч ашиглалтад өгч мэргэжлийн комисс хүрч ирж хүлээж авсан. Тэр өдрөөс хойш энэ хүн нэг ч ирж лифтнийхээ засвар үйлчилгээг хийсэнгүй. Дээрээс нь лифтний паспорт авчирч өгөөгүй ээ. Одоо энэ лифт нь 5 6 7 давхруудынх нь хаалганы дотор талын хаалга нь сул санжганаад шүүрүү боолт нь салаад уначихсан гацчихсан байна. Хэлэхээр энэ хүн ирэхгүй байна аа. Дуудаад дуудлага хүлээж авахгүй байна. Ингээд барьсан болоод хаячих ёстой юм уу? Энэ дээр арга хэмжээ авч өгөөч. Хариуцсан байгууллагад нь гомдол гаргаж байна.</p>	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат		Гомдолын дагуу гүйцэтгэгч Фүшили элеватор ХХК зөрчил арилгаж 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр зөрчил арилгасан тухай албан бичгээр хариу ирүүлсэн.	2025.07.03	утсаар мэдээлэл өгсөн							
12	Гомдол (С.Чинзориг 99119909)	2025.06.20		<p>Улаанбаатар лифт НӨҮГ-т дуудлага өгөхөөр ирэхгүй, ирэхээрээ засахгүй ямар хэцүү газар вэ? Сүүлийн 5 өдөр лифт байнга гацаж, оршин суугчдын тав тух алдагдуулаж байна үүнийг холбогдох газар нь уламжилж өгнө үү.</p>	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат		"Гандирс" СӨХ-ны гүйцэтгэх захирал С.Чинзоригийн гомдлын мөрөөр шалгаж үзэхэд 2025 оны 06 дугаар сарын 16-19-ний өдрийн хооронд 4 дуудлага бүртгэгдсэн ба дуудлага тус бүрт очиж лифтийг хэвийн ажиллагаанд оруулсан байна. Иймээс С.Чинзоригийн гомдол үндэслэлгүй болно. Тус лифт үндсэн инверторын гэмтлийн улмаас байнга гацаж зогсож байгаа тул зайлшгүй солих шаардлагатай талаар гүйцэтгэх	2025.06.23	утсаар мэдээлэл өгсөн							

					захирал С.Чинзоригт тайлбарлаж ойлгуулсан болно.		
13	Санал (Г.Намнансүрэн 80041927)	2025.06.20	СБД-ийн 6 дугаар хорооны 31 дүгээр байрны 2 дугаар орцны лифтийг сольсон юм. Энэ лифтийг хурдан ашиглалтад оруулахыг шаардаж өгнө үү. Манай орцны ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээш доошоо шатаар өгсөхөд хэцүү байна.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн Г.Намнансүрэнд шинэчлэлийн ажил бүрэн дуусаж улсын комисс ажиллахад бэлэн болсон тухай утсаар мэдээлэл өгөв. Улсын комисс хүлээгдэж байна.	2025.06.23 утсаар мэдээлэл өгсөн	
14	Гомдол (Д.Ф 99394262)	2025.08.06	Зуун айлын гүүрэн гарцын 2 цахилгаан шат нь ажиллахгүй байна. Настай хүмүүс дээшээ гарахад маш хэцүү байдалтай байна. Мөн 120-ын гарцын цахилгаан шат ажиллахгүй байна. Энэ асуудлыг яаралтай шийдвэрлэж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	120 мянгатын гүүрэн гарцын лифтийг 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдөр засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Мөн 100 айлын гүүрэн гарцын лифтийн хувьд хаалганы удирдлага эвдэрсэн тул сэлбэг материалыг захиалаад байна.	2025.09.02 утсаар мэдээлэл өгсөн	
15	Хүсэлт (Ц.Эрдэнэцэцэг 99037026)	2025.08.14	120 мянгатын гүүрэн гарцын баруун талын цахилгаан шат ажиллахгүй сар болж байна. Засчих болов уу гэж хараад засахгүй юм. Настай хүмүүст их хэцүү байна. Холбогдох газарт нь уламжилж яаралтай арга хэмжээ авч өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Тус гүүрэн гарцын лифтийг 2025 оны 08 дугаар сарын 31-ний өдөр засварлан хэвийн ажиллагаанд оруулсан.	2025.09.02 утсаар мэдээлэл өгсөн	
16	Гомдол (С.Булганбилэг 91189596)	2025.08.20	БГД-ийн 7-р хороо 33-р байр 2-р орцны лифтийг улсын комисс хүлээж авахгүй байна. Ажиллаагүй 2 сар гаран болж байна. Уг асуудлыг холбогдох газар нь уламжилж, арга хэмжээ авч өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	2025 оны 08 дугаар сарын 14-ны өдөр Улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан.	2025.08.25 утсаар мэдээлэл өгсөн	
17	Гомдол (С.Цогзолмаа 94040272)	2025.09.17	СБД-ийн 11-р хороо, 813-р байр лифт байнга гацаад байна. Энэ талаар хэлэхэд урдаас загнаад байна. Шалгаж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер	Тус 813 дугаар байрны лифтийг 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр засварлан хэвийн ажиллагаанд оруулсан болно.	2025.09.29 утсаар мэдээлэл өгсөн	

18	Гомдол (Д.Батхүү 88105921)	2025.09.24	БЗД-ийн 6-р хороо 22 Б байранд цахилгаан шат улсаас сольсон. 20 гаран орон сууцны цахилгаан шат сольж байгаа учир нэгдсэн журмаар 11 дүгээр сараас цахилгаан шатаа явуулна гэж хэлээд байна. Зурх судасны өвчтэй хүн учир хүндрэлтэй байна. Уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	2025 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх дүүрэгт 23 цахилгаан шатыг 1 багц ажлаар шинэчилж байна. 22Б байрны лифт тус багц ажлаар шинэчлэгдэж байгаа бөгөөд угсралтын ажил дууссан лифтуудийг бүрэн магадлал, туршилт хийлгэн, улсын комисст хүлээлгэн өгөхөөр хүлээгдэж байна.	2025.10.22 Боломжгүй тухай хариу өгсөн
19	Гомдол (Б.Эрдэнэцэцэг 99012092)	2025.12.02	ХУД-ийн 120 мянгатын явганы гүүрэн гарцын лифтээ хэвийн ажиллуулж болдоггүй юм уу? Өглөө бүр очиход л ажиллаж эхлээгүй, жирэмсэн өндөр настан тэрэгтэй хүмүүс гээд хүндрэлтэй байна. Уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн Б.Эрдэнэцэцэгтэй холбогдож гомдол саналыг сонсов. Тухайн өдрийн өглөө лифтчин Уламбаяр ажилласан бөгөөд шөнөдөө гадна температур -29 хэм хүрч хоносон тул лифт царцаад эрт ажиллуулах боломжгүй байсан тул 08.45-д нээсэн байна. Гомдолтой холбоотой бүх гүүрэн гарцын лифтчингүүдэд цаг ашиглалттай холбоотой үүрэг чиглэл өглөө. Холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.	2025.12.05 утсаар мэдээлэл өгсөн

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ДОТООД
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Номин

Э.НОМИН-ЭРДЭНЭ

“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТООН МЭДЭЭ

2025 оны 12 дугаар сарын 30

№	Өргөдөл гомдлын агуулга	Нийт тоо	Хэлбэр				Агуулга					Шийдвэрлэж хариу өгсөн		Шийдвэрлэж байгаа		
			Амаар /бичгээр / аппликейшн	Утсаар	Цахим хэлбэрээр	Дэд байгууллагаас ирсэн	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Мэдэгдэл	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хугацаа хэтрэж хариу өгсөн	Хугацаа болоогүй	Хугацаа хэтрэсэн	
1	Цахим програмд бүртгэгдсэн	19	-	Байхгүй	19	Байхгүй	1	5	13	Байхгүй	Тийм	Байхгүй	-	Байхгүй	-	-
2	Цахим програмд бүртгэгдээгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Нийт	19	-	-	19	-	1	5	13	-	19	-	-	-	-	-

Тайлан мэдээг гаргасан:

Архив, бичиг хэрэг, дотоод

асуудал хариуцсан мэргэжилтэн

Нашин

Э.НОМИН-ЭРДЭНЭ

Улаанбаатар хот